

# ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 01 дугаар сарын 07-ний өдөр 15:00 цаг

**Төслийн нэр:** Ковид-19 цар тахалтай холбогдуулан хэрэгжүүлж буй “Ковидийн эрсдэлийг хамтдаа даван туулья” төсөл

“Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын Байгууллага нь КОВИД -19 цар тахалтай холбогдуулан “Ковидийн эрсдэлийг хамтдаа даван туулья” төсөл хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн Зорилт 1 нь коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтын сөрөг нөлөөнд өртсөн эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг нөхөн сэргээх болон олон нийтийн даван туулах, дэмжлэг үзүүлэх бүтцийг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд төслийн талбар буюу нийслэлийн СХД, СБД, БЗД, Баян-Өлгий, Өвөрхангай аймгууд дахь үйлдвэрлэгч өрх, иргэдийн бүлгүүдийн одоогийн зах зээлийн нөхцөл байдал, бэрхшээл, хэрэгцээ шаардлага, тэдгээрт цартахлын улмаас үүсээд буй сөрөг нөлөөллүүд, бичил бизнес, өрхийн үйлдвэрлэл, үйлдвэрлэгч бүлгүүдийг дэмжих цаашдын гарц, хамгийн боломжит бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг судлах Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтанд оролцохыг урьж байна.

Үнийн санал болон холбогдох материалыг дугтуйд хийн битүүмжилж 2021 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 15.00 цаг Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын Төв оффист авчирна уу. Хаяг: БЗД, 15-р хороо, Соманг Плаза 4 давхар Үнийн санал болон холбогдох материалыг хүлээн авах эцсийн хугацаа

2021 оны 01-р сарын 07-ны өдрийн 15:00 цаг

Сонгон шалгаруулалтанд оролцохыг сонирхож буй

хуулийн этгээд дэлгэрэнгүй мэдээллийг

**mongolia@wvi.org** цахим хаягт хандан авна уу.